



МОНГОЛ УЛС  
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 10 сарын 14 өдөр

Дугаар А/376

Мандалговь

Дуудлага худалдаа зохион байгуулах  
ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалт, Газрын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.2 дахь заалт, Засгийн газрын 2016 оны 10 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тус аймгийн Сайнцагаан сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 12 тоот тогтоолоор батлагдсан 2021 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу иргэн, аж ахуй нэгж байгууллагад худалдаа үйлчилгээний зориулалтаар шинээр эзэмшүүлэх газрын дуудлага худалдаа явуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн дарга: Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Газрын удирдлагын хэлтсийн дарга

Хөтлөгч: Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Газрын төлбөр, үнэлгээ, татварын асуудал хариуцсан мэргэжилтэн

Тэмдэглэл хөтлөгч: Сайнцагаан сумын Газрын даамал

2. Газар эзэмших эрхийн дуудлага худалдаа явуулах ажлын журам, зааврыг баримтлан ил тод, нээлттэй явуулахыг ажлын хэсгийн дарга (Газрын удирдлагын хэлтсийн дарга)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.МӨНХБАТ

481210504